

**Эрх зүйн хийдлийг төсөөтэй зарим
ойлголтоос ялгах асуудалд**

**The Problem of Distinguishing Legal
Gaps from Related Legal Concepts**


Ренчиндоржийн Онончимэг

Хууль зүйн ухааны магистр (LL.M.).

Улаанбаатар хот, Монгол Улс

ononchimeg79@gmail.com

© R.Ononchimeg, 2025



[Attribution-NonCommercial 4.0 International
\(CC BY-NC 4.0\)](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/)

[Товч утга]

Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль батлагдсанаас хойших 30 гаруй жилд манай улсад хууль тогтоомжийн нүсэр их хуримтлал буй болжээ. Эдгээр хууль тогтоомжид эрх зүйн хийдэл, давхардал, зөрчилдөөн нэлээдгүй байгаа нь судалгаагаар нотлогдож байна. Энэ учраас юуны өмнө эрх зүйн хийдэл гэж юу болохыг зөв төсөөлөх зүй ёсны шаардлага үүснэ. Түүнчлэн эрх зүйн тайлбар, хууль бүтээх явцад гаргасан алдаа, хууль тогтоомжийн зөрчилдөөн, хууль зүйн техник зэрэг төсөөтэй ухагдахуунаас зааглан ялгах нь эрх зүйн хийдлийг зөв ойлгоход чухал ач холбогдолтой юм. Энэ зорилгоор өмнө дурдсан хууль зүйн ухагдахууныг шинжлэн судлах зорилтыг энэхүү өгүүлэлд тавьсан нь тус улсын нийт хууль тогтоомжийг ойлгомжтой, тодорхой, цэгцтэй болгох үйлсэд өчүүхэн төдий ч гэсэн тус дөхөм үзүүлэхэд чиглэгдсэн болно.

[Түлхүүр үг]

Эрх зүйн хийдэл, эрх зүйн тайлбар, хууль бүтээх явцад гаргасан алдаа, хууль тогтоомжийн зөрчилдөөн, хууль зүйн техник.

I. Удиртгал

Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн нэгэн зангилаа асуудал нь хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг хийдэл, давхардал, зөрчилдөөнгүй болгох явдал мөн. Энэ зорилгоор эрх зүйн хийдэл гэж юу болох түүнийг эрх зүйн тайлбар, хууль бүтээх явцад гаргасан алдаа, хууль тогтоомжийн зөрчилдөөн, хууль зүйн техник зэрэг төсөөтэй ойлголтоос зааглан ялгах асуудлыг хөндсөн болно.

II. Эрх зүйн хийдлийн мөн чанар

Эрх зүйн хийдлийн тухай асуудал монголын эрх зүйд нэлээд эртнээс яригдаж байжээ. Ганцхан жишээ дурдахад 1924 оны буюу БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийг хэлэлцэх үеэр Улсын Хурлын төлөөлөгч Лувсанчой – Энэхүү Үндсэн хуулийг үүрд журамлан дагаж явах уу? гэхэд Ерөнхий сайд Цэрэндорж – Бид бодвоос үргэлжид дагаж явах Үндсэн хууль хэмээх бөгөөд хэд хэдэн арван мянган жил болоход үл болохоор үгүй. Одоо болбоос харьяа улсын тохинон батадсан зэргээр анх Үндсэн хуулийг батлан буй бөгөөд бас бидний Үндсэн хуульд ороогүй орхигдсон зүйл байж болох тул энэхүү Үндсэн хуулийн зүйл ангиас өөрчлөгдөх нь болзошгүй боловч Улсын Их Хурлаас бус өөрчлөх газар үгүй”¹ гэж мэдэгдэж байжээ. Эндээс үзэхэд Үндсэн хуульд ороогүй орхигдсон зүйл байж болзошгүй гэсэн нь угтаа эрх зүйн хийдлийн тухай асуудал байжээ.

Эрх зүйн хийдлийг академич С.Нарангэрэл 2007 онд “тухайн харилцааны хүрээнд эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардагдаж байгаа бөгөөд хууль зүйн хэм хэмжээг заавал биелүүлэхгүйгээр хэвийн үйл ажиллагааг нь хангах боломжгүйгээр тийм эрх зүйн зохицуулалт бүрэн буюу хэсэгчлэн дутагдах”² гэж тодорхойлсон байна. Хууль зүйн ухааны доктор Д.Баярсайхан 2023 онд “Эрх зүйн хэм хэмжээгээр зайлшгүй зохицуулагдах ёстой харилцаа бүрэн буюу тодорхой хуульчлагдаж чадаагүйгээс хууль зүйн үйлчлэл дутагдаж, эрх зүйн үр дагавар бүхий хий орон зай үүссэн нөхцөл байдал юм”³ гэж тодорхойлжээ. Хууль зүйн шинжлэх ухааны доктор Д.Лүндээжанцан “хуулийн хийдэл гэж тухайн харилцаанд оролцогчдын зан үйлийг хуульчилсан боловч түүнийг хэрэгжүүлэх арга зам, процедурыг заагаагүй, шаардлагатай зохицуулалтыг

¹ БНМАУ-ын анхдугаар их хурал. Дэлгэрэнгүй тайлан, (Улаанбаатар: 1984), 262-263 дахь тал.

² Содовсүрэнгийн Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (анхны хэвлэл), (Улаанбаатар: 2007), 647 дахь тал.

³ Дашхүүгийн Баярсайхан, “Эрх зүйн хийдэл, зөрчилдөөний хэлбэрүүдийг эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний зарим жишээн дээр авч үзэх нь”, Хууль дээдлэх ёс, 92 (1), 2023, 14 дэх тал.

орхигдуулсан, эсхүл зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд зөрчилтэй буюу салаа утгатай байхыг хэлнэ”⁴ гэсэн байна. Энэ тодорхойлолтод шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан гэж бичсэнээрээ өмнө дурдсан эрдэмтдийн тодорхойлолттой утга нэг байгаа боловч хэрэгжүүлэх арга зам, процедурыг заагаагүй, эсхүл зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд зөрчилтэй буюу салаа утгатай гэсэнээрээ ялгаатай болжээ.

Эрх зүйн хийдлийн талаарх төсөөлөл эрх зүйн тодорхой бүл болгонд харилцан адилгүй байгаа ажээ. Эх газрын эрх зүйн бүхий улс орнуудад эрх зүйн хийдлийн тухай асуудлыг нэн чухалчлан үздэг. Яагаад гэвэл эрх зүйн энэ бүлийн улс орнуудад эрх зүйн үндсэн эх сурвалж нь бичмэл хууль ба хэм хэмжээ тогтоосон акт болдог. Манай улсын эрх зүйн тогтолцоо нь эх газрын эрх зүйн бүлийн чиг баримжаа, уламжлалтай билээ⁵. Энэ учраас эх газрын эрх зүйн бүл бүхий улс орнуудын эрх зүйн хийдлийн талаарх хууль зүйн ном зохиол онол-арга зүйн ихээхэн ач холбогдолтой болохыг тэмдэглэх нь зүйтэй юм⁶.

Англо-саксоны эрх зүйн бүл бүхий улс орнуудад эрх зүйн эх сурвалж нь шүүхийн жишиг (прецедент)⁷, эрх зүйн заншил⁸, эрх зүйн номлол⁹ болдог учраас эрх зүйн хийдлийн тухай асуудал эх газрын эрх зүйн бүл шиг нэг их чухалчлагддаггүй харин бичмэл хууль нь эрх зүйн бас нэгэн эх сурвалж болдог тул хууль зүйн техникийн асуудал зохих байр сууринд тавигддаг байна.

Манай улсын дагаж мөрдөж буй хууль тогтоомжид эрх зүйн хийдэл цөөнгүй байгаа нь судалгаагаар тогтоогдсоор байна.

⁴ Данзангийн Лүндээжанцан, *Хууль бүтээх үйл ажиллагаа ба хууль зүйн техник*, (Улаанбаатар: 2016), 108 дахь тал.

⁵ Бярагийн Чимид, *Үндсэн хуулийн үзэл баримтлал*, (Улаанбаатар: 2002), 218 дахь тал.

⁶ *German legal System and Laws* (Third Edition), (Oxford University Press: 2008); Лазарев В. В., *Пробелы в праве: Вопросы понятия пробелов и критика теорий беспробельности права*, (Казань: 1969); Лазарев В. В., *Пробелы в праве и пути их устранения*, (Москва: 1974); Лихачев В. Н., *Пробелы в современном международном праве*, (Казань: 1985); Тихомиров Ю. А., *Юридическая коллизия*, (Москва: 1994); Тихомиров Ю. А., Пиколкин А. С., Рахманин Т. Н., *Как готовить законы* (научно-практическое пособие), (Москва: 1996); Нерсисянц В. С., *“Проблемы пробелов в праве, их восполнение”*, *Проблемы общей теории права и государства*, (Москва: НОРМА, 2006) зэрэг.

⁷ Шүүхийн жишиг (прецедент) нь эзэн хааны, лорд канцлерын, дээд ба давж заалдах шүүхийн шүүгчдийн эрх зүйн мэргэжлийн мэдлэг, мэргэшилд үндэслэж, адил төстэй хэрэг маргааныг шийдвэрлэсэн өмнөх практикийг олон үе дамжуулж хэрэглэх замаар хэвшүүлж заншуулсан хэм хэмжээ юм.

⁸ Англо-саксоны эрх зүйн бүлд заншил байгаа эсэх талаар талууд маргаж байгаа тохиолдолд шүүхээс түүнийг заншил болохыг хүлээн зөвшөөрсөн, шийдвэрийнхээ үндэслэл болгосон нөхцөлд эрх зүйн заншил хэмээн үздэг байна.

⁹ Батболдын Амарсанаа, *Харьцуулсан эрх зүй судлал*, (Улаанбаатар: 2014), 80 дахь тал.

Жишээлбэл, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны захиалгаар 2023 онд хийгдсэн “Байгаль орчны салбарын хуулиудын давхардал, зөрчил, хийдлийг арилгах дүн шинжилгээ хийх, салбарын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах судалгаа”-нд нийт 33 хууль, 234 дүрэм, журам, аргачлал хамрагдсан бөгөөд тэдгээрээс 335 хийдэл байгааг¹⁰ олж тогтоосон байна. Ашигт малтмал болон эрдэс баялгийн салбарт дагаж мөрдөж байгаа 10 гаруй хуульд дүн шинжилгээ хийж үзэхэд 150 хийдэл байгаа нь тогтоогджээ¹¹. Зарим судлаач эрх зүйн хийдлийг тодорхой хуульд үндэслэн судалж байна¹².

Өмнө дурдсаныг нэгтгэн дүгнэж үзвэл эрх зүйн хийдэл нь нийгмийн харилцааны хөгжил ба хэрэг маргааныг шийдвэрлэх эрэлт хэрэгцээгээр нөхцөлдсөн зайлшгүй шаардлагын улмаас эрх зүйн хэм хэмжээ түүний зохицуулалт бүрэн буюу хагас орхигдсон нөхцөл байдал мөн.

Эрх зүйн хийдэл нь хэд хэдэн хэлбэрээр илрэн гардаг учраас хууль зүйн ном зохиол болон хууль зүйн практикт (1) эрх зүйн хийдэл, (2) хууль тогтоомжийн хийдэл, (3) хуулийн хийдэл, (4) эрх зүйн хэм хэмжээний актын хийдэл, (5) эрх зүйн хэм хэмжээний хийдэл хэмээн ангилж байгаа болно¹³. Тухайн нийгмийн харилцааг бүрэн гүйцэд бус зохицуулсан хэр хэмжээг харгалзан эрх зүйн хийдлийг эрх зүйн бүрэн хийдэл ба эрх зүйн хагас хийдэл гэсэн төрөлд ангилна¹⁴.

Эрх зүйн хийдэл үүсэх үндсэн шалтгаан нь нэг талаар объектив шалтгаантай холбоотой бөгөөд энэ нь тухайн хуулийг батлан гаргах үед эрх зүйн зохицуулалт шаардлагатай болсон нийгмийн харилцаа амьдралд үүсэн буй болоогүй, өөрөөр хэлбэл, эрх зүйн зохицуулалт зайлшгүй эрэлт хэрэгцээтэй болсон нь хожим илэрсэн байх явдал юм. Харин судалгаанаас үзэхэд субъектив шалтгаан нь хууль тогтоогч ямар нэгэн шалтгааны улмаас тухайн эрх зүйн зохицуулалтыг дутуу дулимаг боловсруулсан, алдаа гаргасан, яв цав тодорхойлж чадаагүй, эрх зүйн хэм хэмжээний өөр хооронд зөрчилдөөн буй болгосон зэрэгтэй салшгүй холбоотой байдаг ажээ.

¹⁰ *Байгаль орчны салбарын хуулиудын давхардал, зөрчил, хийдлийг арилгах дүн шинжилгээ хийх, салбарын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах судалгаа*, (2023), 1098 дахь талыг үзнэ үү.

¹¹ Пүрэвдолгорын Одгэрэл, “Захиргааны эрх зүйн тусгай ангийн системчлэлийн онолын асуудал”, *Захиргааны эрх зүйн системчлэл, хэрэглээ: харилцан хамаарал. Эмхэтгэл*, (Улаанбаатар: 2024), 49 дэх талыг үзнэ үү.

¹² Энхбаярын Уянга, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн давхардал, зөрчил, хийдлийн талаарх асуудал”, *Хууль дээдлэх ёс*, 39 (4), 2012, 120-129 дэх тал.

¹³ Ренчиндоржийн Онончимэг, *Эрх зүй, түүний хийдэл*, (Улаанбаатар: 2025), 51-56 дахь талаас тодруулж үзнэ үү.

¹⁴ *Мөн тэнд*, 56-64 дэх талаас тодруулж үзнэ үү.

Эрх зүйн хийдэл нь эрх зүйн тайлбар, хууль бүтээх явцад гаргасан алдаа, хууль тогтоомжийн зөрчилдөөн, хууль зүйн техник зэрэгтэй их ойролцоо байдаг учраас тэдгээрээс зааглан ялгах зайлшгүй шаардлага үүсэн гарна.

III. Эрх зүйн тайлбараас ялгах нь

Эрх зүйн хийдлийг эрх зүйн тайлбартай адил мэт үзэж, эрх зүйн тодорхой заалтын агуулгын учрыг тайлж чадахгүй болохлоороо эрх зүйн хийдэл байна хэмээн будилах явдал амьдралд нэлээдгүй гарч байна. Эрх зүйн тайбар нь нэг талаас эрх зүйн хэм хэмжээний утга санааг (агуулгыг) тогтооход чиглэгдсэн танин мэдэхүйн нарийн үйл явц, нөгөө талаас тайлбарлаж буй хэм хэмжээний агуулгыг нээн тайлсан, тусгасан бодомжийн цогцоор илэрхийлэгдсэн үйл явцын үр дүн мөн. Гэтэл эрх зүйн хийдэл нь хуулийг хэрэглэхэд эрх зүйн зохицуулалт бүрэн буюу эсхүл бүрэн гүйцэд бус дутагдсан байх явдал юм. Эдгээр ойлголтын хоорондын зааг ялгаа чухам үүнд оршино.

IV. Хууль бүтээх бүтээх явцад гаргасан алдаанаас ялгах нь.

Эрх зүйн хийдэл нь хууль бүтээх явцад гаргасан алдаатай нэн ойролцоо байдаг. Энэ учраас хууль бүтээх явцад гаргасан алдаанаас эрх зүйн хийдлийг зааглан ялгах зайлшгүй шаардлага үүснэ. Хуулийг бүтээх явцад гаргасан алдаа нь оршин буй объектив нөхцөлийг хууль тогтоогч хууль тогтоомжид буруу тогтоосон явдалтай холбогдон үүсдэг. Судалгаанаас үзэхэд хууль бүтээх явцад а) хууль тогтоогч аливаа нэгэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагагүй гэж үзсэнтэй холбогдон үүссэн алдаа; б) хууль тогтоогч тухайн хуулийн хэм хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулан тогтоож чадаагүйтэй холбогдсон алдаа; в) хууль тогтоогчийн зүгээс хууль хэрэглэх явцад хуулийг тодорхой, ойлгомжтой болгож болно гэж үзсэнтэй холбогдсон алдаа; г) хууль тогтоогч хууль хэрэглэгчийн үзэмжээр шийдвэрлэх боломжтой гэж үзсэнтэй холбогдсон алдаа; д) хууль тогтоогч зайлшгүй шаардлагагүй байхад уг хууль баталсантай холбогдсон алдаа зэрэг алдаа гарч байна. Эдгээрээс “а”, “б”, “в”, “г”-д дурдсан алдаа нь хууль хэрэглэх явцад илрэн гардаг бөгөөд тэдгээрийг зөвхөн хууль тогтоох байгууллага л арилгах боломжтой.

V. Хууль тогтоомжийн зөрчилдөөнөөс ялгах нь

Сүүлийн жилүүдэд манай улсын хууль зүй судлалд “харшилдаан”¹⁵, “хуулиудын коллизи”¹⁶, “Үндсэн хуулийн зөрчил”¹⁷, “хууль тогтоомжийн зөрчил”¹⁸, “эрх зүйн зөрчилдөөн”¹⁹, “хууль зүйн зөрчилдөөн”²⁰, “позитив эрх зүйн дотоод зөрчилдөөн”²¹ ба “хуулиудын зөрчилдөөн”²² зэрэг нэг ухагдахууныг олон янзаар нэрлэсэн нэр томьёо нэлээдгүй хэрэглэгдэх болсон. Эрх зүйн хийдлийг эрх зүйн зөрчилтэй хольж хутгаж болохгүй. Эрх зүйн зөрчил бол эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн, нийгэмд аюултай, хууль зүйн хариуцлага хүлээлгэхээр тогтоомжид заасан, эрх зүйн чадамжтай этгээдийн гэм буруутай үйл (үйлдэл буюу эс үйлдэхүй) юм. Эрх зүйн ерөнхий онол ёсоор эрх зүйн зөрчлийг гэмт хэрэг, захиргааны эрх зүйн зөрчил, иргэний эрх зүйн зөрчил, сахилгын зөрчил хэмээн ангилдаг. Эрх зүйн нэг ухагдахууныг олон янзаар нэрлэсэн нь практикт ихээхэн ойлгомжгүй байдлыг буй болгожээ.

Харин нэг буюу тухайн нийгмийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийн хооронд авцалдаагүй байдал үүссэнийг хууль тогтоомжийн зөрчилдөөн гэж цаашид нэрлэж хэвшүүлэх саналыг дэвшүүлж байна. Хэрэв ингэхгүй бол хууль тогтоомжийн зөрчилдөөнийг “хууль тогтоомжийн зөрчил”, “хуулийн зөрчил”, “эрх зүйн зөрчил” гэсэн нэр томьёоноос зааглан ялгах боломжгүй болох юм. Хууль тогтоомжийн зөрчилдөөн нь нэг буюу эсхүл төсөөтэй нийгмийн харилцааг зохицуулж буй тодорхой хуулиуд өөр хоорондоо авцалдахгүй байх ба зөрчилдөх, түүнчлэн хууль хэрэглэх ба эрх бүхий байгууллага ба албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад үүссэн зөрчилдөөн мөн. Хууль тогтоомжийн зөрчилдөөн нь эрх зүйн үндэсний тогтолцооны хэвийн үйл ажиллагаанд саад учруулж, иргэдийн эрхийг хөндөж, эрх зүйн зохицуулалт, эрх зүйн дэг журам,

¹⁵ Жүгнээгийн Амарсанаа, *Англи-орос-герман-монгол олон улсын эрх зүйн толь*, (Улаанбаатар: 2004), 174-175 дахь тал.

¹⁶ *Хууль зүйн тайлбар толь*, (Улаанбаатар: 2003), 316-317 дахь тал.

¹⁷ Баянбаатарын Батбаяр, Мөнхбаярын Цэдэвсүрэн, *Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх* (Тойм лавлагаа, харьцуулсан судалгаа, дүн шинжилгээ), (Улаанбаатар: 2019), 153 дахь тал.

¹⁸ Данзангийн Лүндэжанцан, өмнөх эшлэл 4, 108-114 дэх тал; Сарантуяагийн Болормаа, Г. Билгээ, *Хууль зүйн техник. Хуулийн төсөл боловсруулах арга зүй - II*, (Улаанбаатар: 2023), 111 дэх тал. Хуулийн төсөл боловсруулах арга зүй - II. Улаанбаатар., 2023, 111 дэх тал.

¹⁹ Осорын Амархүү, *Эрх зүйн онолын лекцүүд*, (Улаанбаатар: 2009), 121 дэх тал.

²⁰ Содовсүрэнгийн Нарангэрэл, *Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг* (Дөрөв дэх хэвлэлт), (Улаанбаатар: 2015), 564 дэх тал.

²¹ Чойжилын Нямсүрэн, *Эрх зүйн ерөнхий онол* (III хэвлэл), (Улаанбаатар: 2024), 320-321 дэх тал.

²² Содовсүрэнгийн Нарангэрэл, *Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг*, (Улаанбаатар: 2021), 522 дахь тал.

нийгмийн эрх зүйн ухамсар ба эрх зүйн соёлын үр нөлөөг эрс бууруулдаг юм. Хууль тогтоомжийн зөрчилдөөн нь хууль хэрэглэх практикт хүндрэл учруулж, жирийн иргэд хууль тогтоомжийг ашиглахад бэрхшээл буй болгож, эрх зүйг үгүйсгэх үзэл газар авахад хүргэх сөрөг үр дагаврыг дагуулдаг.

Судалгаанаас үзэхэд хууль тогтоомжийн зөрчилдөөн нь а) Үндсэн хууль ба бусад хууль тогтоомжийн хооронд; б) тодорхой хууль ба Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хооронд; в) тодорхой хууль ба өөр бусад хууль тогтоомжийн хооронд; г) хууль ба захиргааны хэм хэмжээний актын хооронд; г) нэг байгууллагаас өөр өөр цаг хугацаанд гаргасан эрх зүйн хэм хэмжээний актын²³ хооронд; д) янз бүрийн байгууллагуудын эрх зүйн хэм хэмжээний актын хооронд үүсэж байна²⁴.

VI. Хууль зүйн техникээс ялгах нь

Хууль зүйн техник нь хуулийг түүний агуулга ба мөн чанарын дагуу үр нөлөөтэй тодорхойлох ба логик дэс дараалалтай, уялдаатай томъёолох журам ба арга барилын тогтолцоо юм. Хуулийн бүтэц нь хууль зүйн техникт чухал байр суурийг эзэлдэг бөгөөд практикийн ихээхэн ач холбогдолтой байдаг. Хуулийн эх бичвэрт эрх зүйн материалыг зөв хуваарилсанаар түүний бүтцийг тодорхой, ойлгомжтой, логик дэс дараалалтай болгож, хуулийн агуулгын талаар чиг баримжаагаа түргэн олоход тус дөхөм үзүүлнэ. Хуулийн бүтцийн бүрдүүлбэр хэсэгт хуулийн гарчиг (нэр), хуулийн зорилт, хуулийн хэм хэмжээ-эрх зүйн агуулга багтана. Хуулийн хэм хэмжээ-агуулгын эх бичвэр нь:

1) Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан;

²³ Хууль зүйн үүднээс “эрх зүйн хэм хэмжээний акт” ба “эрх зүйг хэрэглэх акт” гэсэн нэр томъёо өөр хоорондоо зарчмын ялгаатай болохыг тэмдэглэж байна. Эрх зүйн хэм хэмжээний акт гэсэн нэр томъёогоор төрийн эрх бүхий байгууллагаас баглан гаргасан, эрх зүйн хэм хэмжээг агуулсан актыг тусган илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, эрх зүйн хэм хэмжээний акт нь удаан хугацаагаар, олон удаа хэрэглэгдэхэд чиглэгдсэн заалт юм. Тэгвэл эрх зүйг хэрэглэх акт нь эрх зүйн хэм хэмжээ ба тодорхой субъектын эрх ба үүргийг тодорхойлсон хууль зүйн үйл баримтад үндэслэн гаргасан нэг бүрчилсэн эрх зүйн акт юм. Эрх зүйг хэрэглэх актыг “эрх зүйн акт”, “захиргааны акт” зэргээр янз бүрээр нэрлэдэг. Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлд “Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно” гэж заасан байна.

²⁴ Эдгээр зөрчилдөөний талаар Ренчиндоржийн Онончимэг, *өмнөх эшлэл* 13, 104-113 дахь талаас тодруулж үзнэ үү.

2) тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан;

3) тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгаагүй;

4) тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгаагүй;

5) хуулийн зүйл, хэсэг хоорондоо зөрчилдөөнгүй;

6) тухайн хуульд байнгын, тодорхой бус урт удаан хугацаагаар зохицуулах зүйлийг бүрэн тусгасан;

7) хэм хэмжээний бус, тунхаглалын шинжтэй заалт оруулаагүй;

8) бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг маш тодорхой болгож, хуулийн гарчиг болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан²⁵ зэрэг шаардлагыг хангасан байх ёстой.

VII. Дүгнэлт

Өмнө дурдсаныг нэгтгэн дүгнэж үзвэл эрх зүйн хийдэл нь эрх зүйн тайлбар, хуулийг бүтээх явцад гаргасан алдаа, хууль тогтоомжийн зөрчилдөөн, хууль зүйн техниктэй нэн ойролцоо учраас эдгээрээс зааглан ялгахгүй бол эрх зүйн хийдлийг зөв тогтоох боломж алдагдана.

Эрх зүйн тайлбар нь хуулийг нэг мөр сахин биелүүлэхийн тулд түүний заалтын утга санааг тайлах хууль зүйн танин мэдэхүйн үйл ажиллагаа байдгаараа эрх зүйн хийдлээс ялгагдана.

Хуулийг бүтээх явцад гаргасан алдаа нь оршин буй объектив нөхцөлийг хууль тогтоогч хууль тогтоомжид буруу тогтоосон явдалтай холбогддог шинжээрээ эрх зүйн хийдлээс ялгагдана.

Хууль тогтоомжийн зөрчилдөөн нь тухайн нийгмийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомж буюу түүний эрх зүйн хэм хэмжээний хооронд үүссэн авцалдаагүй байдал байдаг онцлогтой.

Хууль зүйн техник нь хуулийг түүний агуулга ба мөн чанарын дагуу үр нөлөөтэй тодорхойлох ба логик уялдаа дараалалтай томъёолох журам ба арга барилын тогтолцоо юм. Энэ учраас эрх зүйн хийдлийг өмнө дурдсан хууль зүйн төсөөтэй ойлголтоос зааглан ялгах зайлшгүй шаардлагатай болдог байна.

²⁵ Мөн тэнд, 46 дахь талыг үзнэ үү.

[Ном зүй]

Баянбаатарын Батбаяр, Мөнхбаярын Цэдэвсүрэн, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх (Тойм лавлагаа, харьцуулсан судалгаа, дүн шинжилгээ), Улаанбаатар, 2019 он.

Байгаль орчны салбарын хуулиудын давхардал, зөрчил, хийдлийг арилгах дүн шинжилгээ хийх, салбарын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах судалгаа, 2023 он.

Батболдын Амарсанаа, Харьцуулсан эрх зүй судлал, Улаанбаатар, 2014 он.

БНМАУ-ын анхдугаар их хурал. Дэлгэрэнгүй тайлан, Улаанбаатар, 1984 он.

Бяраагийн Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал, Улаанбаатар, 2002 он.

Данзангийн Лүндээжанцан, Хууль бүтээх үйл ажиллагаа ба хууль зүйн техник, Улаанбаатар, 2016 он.

Дашхүүгийн Баярсайхан, “Эрх зүйн хийдэл, зөрчилдөөний хэлбэрүүдийг эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний зарим жишээн дээр авч үзэх нь”, Хууль дээдлэх ёс, 92 (1), 2023 он.

Жүгнээгийн Амарсанаа, Англи-орос-герман-монгол олон улсын эрх зүйн толь, Улаанбаатар, 2004 он.

Захиргааны ерөнхий хууль (2015).

Лазарев В. В., Пробелы в праве и пути их устранения, Москва, 1974.

Лазарев В. В., Пробелы в праве: Вопросы понятия пробелов и критика теории беспробельности права, Казань, 1969 он.

Лихачев В. Н., Пробелы в современном международном праве, Казань, 1985.

Монгол Улсын Үндсэн хууль (1992).

Нерсесянц В. С., “Проблемы пробелов в праве, их восполнение”, Проблемы общей теории права и государства, Москва: НОРМА, 2006 он.

Осорын Амархүү, Эрх зүйн онолын лекцүүд, Улаанбаатар, 2009 он.

П.Одгэрэл, “Захиргааны эрх зүйн тусгай ангийн системчлэлийн онолын асуудал”, Захиргааны эрх зүйн системчлэл, хэрэглээ: харилцан хамаарал. Эмхэтгэл, Улаанбаатар, 2024 он.

Ренчиндоржийн Онончимэг, Эрх зүй, түүний хийдэл, Улаанбаатар, 2025 он.

Содовсүрэнгийн Нарангэрэл, Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг, Улаанбаатар, 2021 он.

Содовсүрэнгийн Нарангэрэл, Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг (Дөрөв дэх хэвлэлт), Улаанбаатар, 2015 он.

Содовсүрэнгийн Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (анхны хэвлэл), Улаанбаатар, 2007 он.

Тихомиров Ю. А., Пиколкин А. С., Рахманина Т. Н., Как готовить законы (научно-практическое пособие), Москва, 1996.

Тихомиров Ю. А., Юридическая коллизия, Москва, 1994.

Хууль зүйн тайлбар толь, Улаанбаатар, 2003 он.

Ц.Болормаа, Г.Билгээ, Хууль зүйн техник. Хуулийн төсөл боловсруулах арга зүй - II, Улаанбаатар, 2023 он.

Чойжилын Нямсүрэн, Эрх зүйн ерөнхий онол (III хэвлэл), Улаанбаатар, 2024 он.

Энхбаярын Уянга, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн давхардал, зөрчил, хийдлийн талаарх асуудал”, Хууль дээдлэх ёс, 39 (4), 2012 он.

German legal System and Laws (Third Edition), Oxford University Press, 2008.

[Abstract]

**The Problem of Distinguishing Legal
Gaps from Related Legal Concepts**

Ononchimeg Renchindorj

Master of Laws (LL.M.).

Ulaanbaatar, Mongolia

Over the three decades since the adoption of Mongolia's 1992 Constitution, the country has accumulated an extensive body of legislation. However, research shows that this growing framework of laws is marked by significant gaps, overlaps, and inconsistencies. This reality highlights the need to develop a precise understanding of what constitutes a legal gap. Equally important is the task of distinguishing legal gaps from related notions, such as errors in legal interpretation, shortcomings in the law-making process, conflicts between legal provisions, and issues of legislative technique. The purpose of our study is to examine and clarify these concepts, with the broader aim of contributing—albeit modestly—to the creation of a clearer, more coherent, and systematically organized legal system in Mongolia.

[Keywords]

Legal gap, Legal interpretation, Legislative errors, Legal inconsistency, Legislative technique.